



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/182

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 30 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн “Хөрөнгө шийдвэрлэх тухай” А/144 дүгээр захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох бүртгэх, худалдах, шилжүүлэх журам”-ын 3.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг, газрын хамт газрын биржийн цахим системийг ашиглан дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Валя (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ерөнхий санхүүч)

Н.Сэдэд (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын төсөв, санхүү хариуцсан ахлах мэргэжилтэн)

Э.Хорлоо (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Г.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хариуцсан мэргэжилтэн)

2.Дуудлага худалдааг 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Ц.Идэрсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100384